



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/143

Сүхбаатар сум

Ерөнхий боловсролын сургуулиудын дунд  
“Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт  
болзолт уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а” Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг аймгийн хэмжээнд 2019 оны 05 дугаар сарын 01-нээс 2020 оны 05 дугаар сарын 01-ний хооронд зохион зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Энхбат

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Д.Эрдэнэбат

-Аймгийн Барселон олимпын зөвлөлийн  
дарга

Гишүүд:

Ч.Жаргалсайхан

-Аймгийн Боловсрол, соёл урлагийн  
газрын дарга

У.Батмөнх

-Аймгийн Биеийн тамир спортын газрын  
дарга

О.Наранбаатар

-Сүхбаатар сумын ерөнхий боловсролын  
Спортын дунд сургуулийн захирал

Э.Оюун-Эрдэнэ

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Л.Аззаяа

-Аймгийн Биеийн тамир спортын  
газрын мэргэжилтэн

2. Болзолт уралдааны удирдамжийг баталгаажуулан удирдлага зохион байгуулалтаар ханган чаназын өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ